



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/23

Баян-Өндөр сум

Идэвхтэй илрүүлэг үзлэг шинжилгээ
зохион байгуулж, хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2024 оны "Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, заавар батлах тухай" А/38 дугаар тушаал, аймгийн засаг даргын 2024 оны хөрөнгө гаргах тухай А/233 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Сүрьеэгийн хавьтлын хяналтын үзлэг шинжилгээний хамралтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн"-ийг нэгдүгээр, "Сүрьеэгийн эрсдэлт бүлэг болон хавьтлын үзлэг шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах удирдамж"-ийг хоёрдугаар, эрт илрүүлэг үзлэгийн тоон тайлан гаргах хүснэгтийг гуравдугаар, шаардагдах төсвийг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
2. Арга хэмжээг үр дүнтэй, хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах 7.000.000 (долоон сая) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл, мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (А.Ганчимэг)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 04 дүгээр сарын 03 ний
өдрийн дугаар тушаалын
мэдүгээр хавсралт

5043446 2020030036

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

ЭМГ-ын ДЗХӨАХМ П. Отгонбилэг

Гишүүд:

БОЭТ-ийн сүрьеэгийн эмч Б.Батсуурь

БОЭТ-ийн сүрьеэгийн эмч М.Пүрэвдорж

БОЭТ-ийн сүрьеэгийн эмч М.Ариунсүвд

БОЭТ-ийн сүрьеэгийн амбулаторийн сувилагч П.Цэгмид

БОЭТ-ийн сүрьеэгийн лаборант Д.Нямдаваа

БОЭТ-ийн сүрьеэгийн амбулаторийн сайн дурын ажилтан Б.Энхтуяа

СӨЭМТ-ийн сүрьеэгийн асуудал хариуцсан эмч, сувилагч

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 04 дүгээр сарын 03-ний
өдрийн 2 дугаар тушаалын
2 хоёрдугаар хавсралт

9043446 2020030036

СҮРЬЕЭГИЙН ЭРСДЭЛТ БҮЛЭГ БОЛОН ХАВЬТЛЫН ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН УДИРДАМЖ

Үндэслэл:

2023 онд улсын хэмжээнд 3181 сүрьеэгийн тохиолдол бүртгэгдсний 1083 нь аймаг орон нутагт бүртгэгдсэн. Орхон аймагт 2023 онд сүрьеэгийн 75 тохиолдол бүртгэгдсний 3 нь хүүхдийн сүрьеэгийн тохиолдол, 4 нь олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдол бүртгэгджээ. Хүүхдийн сүрьеэгийн тохиолдол нэмэгдэх хандлагатай байгаа хүн амын дундах сүрьеэгийн тархалт өндөр байгааг илтгэх үзүүлэлт юм. Олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдлын бүртгэлээр Орхон аймаг Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн дараа 3-рт байгаа нь сүрьеэгийн тусламж үйлчилгээний цар хүрээг өргөжүүлж идэвхтэй илрүүлэлтийг тогтмол зохион байгуулах шаардлагатай байгааг харуулж байна. Нийт бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын 69,2% нь уушгины сүрьеэ, 30,8% нь уушгины бус сүрьеэ (булчирхай, яс, үений, олон эрхтний) байна.

2023 онд сүрьеэгийн эрсдэлт бүлэг болон хавьтлын үзлэг шинжилгээг 2 удаа зохион байгуулж 722 хүнийг хамруулснаас сүрьеэгийн 7 тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан, 4 иргэнийг урьдчилсан сэргийлэх эмчилгээнд хамрагдсан байна. Сүрьеэгийн хавьтлын тандалт судалгааг хийхэд гэр бүлийн гишүүн, ажлын газраа нуух, эрт илрүүлэг үзлэгт орохоос татгалзах зэрэг хүндрэлийн улмаас 2022, 2023 онд сүрьеэгийн тохиолдлын нийт хавьтлын 70%-ийг үзлэг шинжилгээнд хамруулсан.

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ард иргэдийн дунд сүрьеэ өвчний талаарх ойлголт хангалтгүйгээс сүрьеэ өвчний оношилгооны хожимдол гарах, үзлэг шинжилгээнд хамрагдахаас татгалзах хандлага байсаар байна.

Иймд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сүрьеэ өвчний шинж тэмдгийн оношилгоо, эмчилгээний шинэ мэдээллийг хүргэх, талаар мэдлэг сэргээх, чадавхжуулах сургалт зохион байгуулах, сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэд хамрагдвал зохих эрсдэлт бүлгийн судалгааг гаргах, идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулах, иргэдийн дунд сүрьеэ өвчний талаарх мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Зорилго: Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэд хамрагдвал зохих эрсдэлт бүлгийн иргэдийг холбогдох үзлэг шинжилгээнд хамруулан, өвчлөлийг эрт илрүүлж, хяналтад авах, сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

Зорилт:

1. Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэд хамрагдвал зохих эрсдэлт бүлгийн иргэдийг холбогдох үзлэг шинжилгээнд хамруулах
2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сүрьеэ өвчний оношилгоо, шинж тэмдгийн талаар мэдлэг сэргээх, чадавхжуулах сургалтад хамруулах

3. Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад дэмжлэгт хяналт хийх

Хамрах хүрээ:

- Сум, ерхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн дотор, хүүхэд, мэс засал, дүрс оношилгооны эмч, мэргэжилтнүүд
- Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэд хамрагдвал зохих эрсдэлт бүлгийн хүн ам

Хамтран ажиллах байгууллага: Аймгийн засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сүрьеэгийн диспансер, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн **сүрьеэгийн тандалт судалгааны алба**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэд хамрагдвал зохих эрсдэлт бүлгийн судалгааг гаргаж, холбогдох үзлэг шинжилгээнд хамруулах.
- Эрсдэлт бүлгийн иргэдээс асуумж судалгаа, цээжний зураг авах, сэжигтэй тохиолдлоос цэрний сорьц цуглуулах.
- Уушгины эерэг сүрьеэ илэрсэн тохиолдлуудын ойрын хавьталд туберкулины сорил тавьж далд хэлбэрийн сүрьеэг илрүүлэх.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сүрьеэ өвчний оношилгоо, шинж тэмдгийн талаар мэдлэг сэргээх, чадавхжуулах сургалт зохион байгуулах
- Сүрьеэгийн диспансер, сүрьеэгийн тасаг, эмзүйн алба, ерхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төвд дэмжлэгт хяналт хийх, зөвлөмж хүргүүлэх /дэмжлэгт хяналт хийх болон хичээл заах багш нарын замын зардлыг халдварт өвчин судлалын үндэсний төвийн сүрьеэгийн тандалт сэргийлэлтийн алба хариуцна/

Хугацаа:

1. Дэмжлэгт хяналт – 2024 оны 04 сарын 1-5-ны өдрүүдэд
2. Идэвхтэй илрүүлэг –2024 оны 04 сарын 8-20-ны өдрүүдэд тус тус зохион байгуулагдана.

Идэвхтэй илрүүлэг үзлэг, шинжилгээ зохион байгуулах хуваарь

№	Үзлэг хийгдэх эрүүл мэнд төв	Хамрагдвал зохих хүний тоо	Хугацаа
1	Нийцэл ӨЭМТ	60	2024.04.08
2	Анхны-Оч ӨЭМТ	60	2024.04.09
3	Мэндцэцэн ӨЭМТ	60	2024.04.10
4	Учралтбаяр ӨЭМТ	80	2024.04.11-12
5	Үйлсбадрах ӨЭМТ	65	2024.04.15
6	Мөнхсүндэрэл ӨЭМТ	80	2024.04.16-17
7	Мөнхийнгэгээ ӨЭМТ	65	2024.04.18

8	Энхжихмандариваа ӨЗМТ	65	2024.04.19
9	Жаргалант СЭМТ	40	2024.04.20
10	Нийт	575	

Хүрэх үр дүн:

1. Сүрьеэгийн эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх, сүрьеэ өвчний хүндрэл, нас баралтыг бууруулна.
2. Аймгийн хэмжээнд сүрьеэтэй өвчтөний хавьтлыг бүрэн тогтоож, тархвар зүйн заалтын дагуу эрт илрүүлэн хяналтад авч сүрьеэгийн тархалтыг бууруулна.
3. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн сүрьеэ өвчнийг эрт үед оношлох чадавх нэмэгдэнэ.
4. Сүрьеэгийн тусламж үйлчилгээний одоогийн нөхцөлд байдлыг үнэлнэ.

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 04 дүгээр сарын 03-ний
өдрийн 1/1 дугаар тушаалын
гурбадугаар хавсралт

5013446 2020010036

**Сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг зохион
байгуулсан тухай тоон тайлан**

№	Үйл ажиллагаа	Үзлэг хийсэн сумын нэр		Нийт
		Баян-Өндөр	Жаргалант	
1. Асуумж судалгаа				
1.1	Бүртгэгдсэн хүний тоо /үзлэгт ирсэн/			
1.2	Асуумж-ярилцлагад хамрагдсан оролцогчийн тоо			
1.3	≥14 хоног ханиалгах шинж илэрсэн оролцогчийн тоо			
2. Рентген шинжилгээ				
2.1	Рентген шинжилгээнд хамрагдсан оролцогчийн тоо			
2.2	"Хэвийн бус - цэр авах" оролцогчийн тоо			
2.3	"Илэрхий сүрьеэ-цэр авах" оролцогчийн тоо			
3. Сүрьеэтэй байж болзошгүй оролцогчийн тоо				
3.1	Нийт			
3.2	Зөвхөн рентген шинжилгээгээр			
3.3	Зөвхөн асуумжаар			
4. Лабораторийн шинжилгээ, онош баталгаажуулалт				
4.1	Цэрний шинжилгээнд хамрагдсан оролцогчийн тоо			
4.2	Нян судлалаар батлагдсан өвчтөний тоо			
4.3	Эмнэлзүйгээр оношлогдсон өвчтөний тоо			
5. Хавьтлын хяналт, далд халдвар илрүүлэлт				
5.1	Туберкулины сорил тавьсан			
5.2	Далд халдвар илэрсэн тоо			
5.3	Далд халдварын эмчилгээнд хамруулсан хүний тоо			

Тайлан нэгтгэсэн:

/БОЭТ-ийн сүрьеэгийн диспансер/

Хянасан:

/ЭМГ-ын мэргэжилтэн/

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 07 дүгээр сарын 03-ний
өдрийн 1/2 дугаар тушаалын
дөрөвдүгээр хавсралт

**СҮРЬЕЭГИЙН ЭРСДЭЛТ БҮЛЭГ, ХАВЬТЛЫН ИДЭВХТЭЙ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ
ШИНЖИЛГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА**

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун	л	450л	2490	1,121,000
2	Хоол	ш	66	25,000	1,650,000
3	Утасны нэгж	т	17	15,000	255,000
4	Томилолтын мөнгө	т	16	24,000	384,000
5	Үзлэгийн зардал	т	575	5000	2,875,000
6	Бичиг хэргийн зардал	т	575	1243	715,000
Нийт дүн					7,000,000